



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МОНГОЛЫН УРАН ЗУРГИЙН ГАЛЕРЕЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/392/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: С.Нацагдорж Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Батсүх Утас: 261628 Цахим хаяг: batsukhts@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "ЦЭБЭ Консалтинг аудит" ХХК-ийн захирал: Д.Энхбаатар Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/663
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын уран зургийн галерейн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 23,960.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монголын уран зургийн галерей нь тайлант хугацаанд нийт 144,650.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, иргэд олон нийтэд музейн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын биет бус өвийг хадгалан хамгаалах, сурталчлах зорилгоор 7 төслийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 48,900.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 217,722.1 мянган төгрөг, нийт 266,622.1 мянган төгрөгийг бүрдүүлж, 261,777.7 мянган төгрөгийг зарцуулж, 4,844.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Бусад асуудал

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хүрээнд төрт ёсны уламжлал, түүх соёлын дурсгал, Монголын дүрслэх урлагийн бүтээлийг олон нийт, хүүхэд, залуучуудад сурталчлах, соёлын боловсрол олгох хөтөлбөрүүдийг тайлант хугацаанд хэрэгжүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	153,690,722.36	192,208,782.19
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
312	Банканд байгаа бэлэн мөнгө	-	-
33	АВЛАГА	7,271,154.69	6,091,154.69
335	Бусад авлага	7,271,154.69	6,091,154.69
3352	Хувь хүмүүсээс авах авлага	7,271,154.69	6,091,154.69
35	БАРАА МАТЕРИАЛ	146,419,567.67	186,117,627.50
351	Түүхий эд материал	24,685,831.01	24,176,831.01
35110	Тусгай зориулалттай материал	24,685,831.01	24,176,831.01
354	Хангамжийн материал	121,733,736.66	161,940,796.49
35410	Бичиг хэргийн материал	5,163,730.00	24,378,360.00
35420	Аж ахуйн материал	6,544,650.00	2,902,638.00
35450	Барилгын засварын материал	-	882,750.00
35470	Бусад хангамжийн материал	110,025,356.66	133,777,048.49
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,849,997,683.81	15,937,986,306.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,849,997,683.81	15,937,986,306.68
392	Биет хөрөнгө	15,849,974,767.29	15,919,336,306.68
39205	Машин тоног төхөөрөмж	184,919,564.42	195,801,134.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(54,762,794.38)	(51,118,973.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	265,959,293.00	277,890,195.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(78,801,306.75)	(66,896,060.45)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,530,360,444.00	15,561,360,444.00
39217	Ном	2,299,567.00	2,299,567.00
393	Биет бус хөрөнгө	22,916.52	18,650,000.00
39301	Программ хангамж	1,200,000.00	19,850,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,177,083.48)	(1,200,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	16,003,688,406.17	16,130,195,088.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,003,688,406.17	16,130,195,088.87
51	Засгийн газрын хувь оролцоо	16,003,688,406.17	16,130,195,088.87
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	693,724,428.90	693,724,428.90
51101	Өмч: - төрийн	693,724,428.90	693,724,428.90
512	Хуримтлагдсан үр дүн	1,056,518,909.27	1,183,025,591.97
51210	Өмнөх үеийн үр дүн	949,077,532.87	1,056,518,909.27
51220	Тайлант үеийн үр дүн	107,441,376.40	126,506,682.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	14,253,445,068.00	14,253,445,068.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	16,003,688,406.17	16,130,195,088.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,064,309,876.39	1,297,585,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	93,494,292.67	28,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	93,494,292.67	28,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	93,494,292.67	28,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	970,815,583.72	1,269,585,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	737,719,300.00	1,004,142,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	737,719,300.00	1,004,142,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	233,096,283.72	265,442,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө	105,564,250.00	48,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон нэмэлт орлого	127,532,033.72	216,542,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	956,868,499.99	1,170,997,692.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	956,868,499.99	1,170,997,692.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	873,535,588.28	1,094,245,321.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,262,885.36	515,679,712.79
210101	Үндсэн цалин	168,532,537.96	297,896,599.99
210102	Нэмэгдэл	44,264,616.94	84,945,643.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,516,216.46	85,499,455.00
210104	Урамшуулал	48,949,514.00	47,338,014.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,402,849.93	64,183,942.87
210201	Тэтгэврийн даатгал	25,906,576.93	43,556,742.87
210202	Тэтгэмжийн даатгал	3,027,752.00	5,156,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,229,098.00	2,578,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	567,937.00	2,578,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,671,486.00	10,313,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,025,600.00	155,025,600.00
210304	Байрны түрээс	155,025,600.00	155,025,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,777,024.00	75,625,871.60
210401	Бичиг хэрэг	8,280,698.00	42,535,016.00
210402	Тээвэр, шатахуун	-	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,230,593.23	2,139,150.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,915,732.77	30,551,705.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,836,400.00	-
210601	Багаж техник хэрэгсэл	356,400.00	-

210604	Урсгал засвар	93,480,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	16,808,246.08	4,950,000.00
210701	Гадаад албан томилолт	8,032,246.08	-
210702	Дотоод албан томилолт	8,776,000.00	4,950,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,917,816.30	213,726,442.17
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	187,914,566.30	203,516,342.17
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	7,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,003,250.00	3,210,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,504,766.61	65,053,752.13
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,504,766.61	65,053,752.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,332,911.71	76,752,370.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,840,619.00	71,507,241.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,445,500.00	19,267,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,395,119.00	52,240,041.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,492,292.71	5,245,129.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,717,410.71	400,709.74
213304	Хөрөнгийн	774,882.00	4,844,420.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	107,441,376.40	126,587,307.70
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	80,625.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	80,625.00
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	-	(80,625.00)
6	НИЙТ ҮР ДҮН (6)=(3)+(5)	107,441,376.40	126,506,682.70

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	970,815,583.72	1,270,765,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	970,815,583.72	1,270,765,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	737,719,300.00	1,004,142,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	737,719,300.00	1,004,142,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	233,096,283.72	266,622,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө	105,564,250.00	48,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон нэмэлт орлого	127,532,033.72	217,722,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	928,877,863.72	1,145,642,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	928,877,862.72	1,145,642,000.00

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	845,544,952.01	1,068,889,629.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,262,885.36	515,679,712.79
210101	Үндсэн цалин	168,532,537.96	297,896,599.99
210102	Нэмэгдэл	44,264,616.94	84,945,643.80
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,516,216.46	85,499,455.00
210104	Урамшуулал	48,949,514.00	47,338,014.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,402,849.93	64,183,942.87
210201	Тэтгэврийн даатгал	25,710,724.93	43,556,742.87
210202	Тэтгэмжийн даатгал	3,027,752.00	5,156,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,424,950.00	2,578,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	567,937.00	2,578,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,671,486.00	10,313,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,025,600.00	155,025,600.00
210304	Байрны түрээс	155,025,600.00	155,025,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,014,518.00	41,418,234.60
210401	Бичиг хэрэг	12,861,210.00	4,755,290.00
210402	Тээвэр, шатахуун	-	400,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,230,593.23	2,139,150.60
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	350,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,572,714.77	34,123,794.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,060,700.00	390,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,040,200.00	-
210602	Тавилга	1,540,500.00	390,000.00
210604	Урсгал засвар	93,480,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	16,808,246.08	4,950,000.00
210701	Гадаад албан томилолт	8,032,246.08	-
210702	Дотоод албан томилолт	8,776,000.00	4,950,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	188,092,852.64	287,242,139.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	183,369,102.64	277,032,039.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	7,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,723,750.00	3,210,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,877,300.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,795,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,300.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	83,332,911.71	76,752,370.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,840,619.00	71,507,241.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,445,500.00	19,267,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	39,395,119.00	52,240,041.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,492,292.71	5,245,129.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,717,410.71	400,709.74
213304	Хөрөнгийн	774,882.00	4,844,420.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	41,937,720.00	125,123,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	41,947,300.00	125,123,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	41,947,300.00	125,123,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	41,947,300.00	125,123,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	41,947,300.00	125,123,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(41,947,300.00)	(125,123,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(9,580.00)	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,580.00	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,724,428.90	14,253,445,068.00	949,077,532.87	15,896,247,029.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	693,724,428.90	14,253,445,068.00	949,077,532.87	15,896,247,029.77
Тайлант үеийн үр дүн	-	-	107,441,376.40	107,441,376.40
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,724,428.90	14,253,445,068.00	1,056,518,909.27	16,003,688,406.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-

Дахин илэрхийлсэн үлдэгдэл	693,724,428.90	14,253,445,068.00	1,056,518,909.27	16,003,688,406.17
Тайлант үеийн үр дүн	-	-	126,506,682.70	126,506,682.70
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	693,724,428.90	14,253,445,068.00	1,183,025,591.97	16,130,195,088.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татаас санхүүжилтийн орлого	1,004,142,900.00	1,003,742,190.26	(400,709.24)	99.9
Улсын төсвөөс	1,004,142,900.00	1,003,742,190.26	(400,709.24)	99.9
Урсгал	1,004,142,900.00	1,003,742,190.26	(400,709.24)	99.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,004,142,900.00	1,003,742,190.26	(400,709.24)	99.9
Ажиллагчидтай холбогдсон зардал	580,140,400.00	579,863,655.66	(687.21)	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	515,680,400.00	515,679,712.79	(687.21)	100.0
Цалин	297,896,600.00	297,896,599.99	(0.01)	100.0
Цалингийн тусгай нэмэгдлүүд	217,783,800.00	217,783,112.80	(687.20)	100.0
Нийгмийн хамгааллын шимтгэл	64,460,000.00	64,183,942.87	(276,057.13)	99.6
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	54,146,400.00	53,870,342.87	(276,057.13)	99.5
Эрүүл мэндийн даатгал	10,313,600.00	10,313,000.00	-	100.0
Бараа, үйлчилгээний урсгал зардал	424,002,500.00	423,878,534.60	(123,965.40)	99.9
Тогтмол зардал	155,025,600.00	155,025,600.00	-	100.0
Байрны түрээс	155,025,600.00	155,025,600.00	-	100.0
Бусад бараа үйлчилгээний зардал	268,976,900.00	268,852,934.60	(123,965.40)	99.9
Бичиг хэргийн материал	1,200,000.00	3,155,290.00	1,955,290.00	262.9
Тээвэр, шатахууны зардал	2,400,000.00	400,000.00	(2,000,000.00)	16.7
Шуудан, холбооны төлбөр	1,200,000.00	1,839,150.60	639,150.60	153.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	-	(600,000.00)	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	1,977,794.00	(22,206.00)	98.9
Төлбөр, хураамж, жижиг татварууд	96,200.00	-	(96,200.00)	-
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	175,834,400.00	175,834,400.00	-	100.0
Урсгал засварын зардал	27,800,000.00	27,800,000.00	-	100.0

Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	19,267,200.00	19,267,200.00	-	100.0
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	1,004,142,900.00	1,003,742,190.26	(400,709.24)	99.9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	20	20	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	18	18	-	100.0
Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Татаас санхүүжилтийн орлого		266,622,100.00
Бусад төсөвт байгууллагаас		48,900,000.00
Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого		217,722,100.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		266,622,100.00
Бусад бараа үйлчилгээний зардал		266,622,100.00
Бичиг хэргийн материал		1,600,000.00
Шуудан, холбооны төлбөр		300,000.00
Дотоод томилолтын зардал		4,950,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		32,146,000.00
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		164,457,639.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		4,500,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал		1,584,000.00
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		52,240,041.00
Бусад - Төвлөрүүлэх гшилжүүлэг		4,844,420.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		266,622,100.00

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой 5,245.1 мянган төгрөгийн алдааг¹ залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Төсвийн гүйцэтгэлийн тайланд 5,245.1 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлснийг тохируулга хийгээгүй.	1	5,245.1	1	5,245.1			1	5,245.1				
Дүн	1	5,245.1	1	5,245.1			1	5,245.1				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3.2 Аудитаар нийт 23,960.4 мянган төгрөгийн 10 зөрчил² илэрснээс 1,500.0 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж, 14,289.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 6,091.1 мянган төгрөгийн зөрчилд 2 хариуцлага тооцох албан шаардлага, 2,079.4 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосон.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Тус галерей нь өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй, 6,091.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.	1	6,091.2								1	6,091.2		
Байгууллагын захирал нь эрх бүхий этгээдийн шийдвэргүйгээр нэг удаа 1,579.4 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл авсан байна.	1	1,579.4	1	1,579.4									
Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд худалдан авах бараа, ажил үйлчилгээний захиалгыг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй 119,632.1 мянган төгрөгийн өртөгтэй 22 нэр төрлийн 54 ширхэг хөрөнгө, 103,145.7 мянган төгрөгийн өртөгтэй 35 нэр төрлийн	1	-								1	-		

² Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.												
Албан томилолтоор ажиллах үеийн хоолны хөнгөлөлт, албан хаагчийн хоолны зардлын нөхөх төлбөрийг давхардуулан тооцож 500.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	500.0	1	500.0								
Хүчин төгөлдөр бус Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам” журмын заалтыг үндэслэж, захирлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/67 тушаалын дагуу үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах эрх нээлгэж, байгууллагын 17 ажилтанд 52,240.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж урамшуулал олгосон байна. Аудитын явцад тушаалын эх хувийг засварлаж Сангийн сайдын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/282 тоот тушаалыг үндэслэсэн болгож өөрчилсөн.	1	-			1	-						
Галерейн ажилтнуудад тушаал шийдвэргүйгээр 14,289.8 мянган төгрөгийг бодож олгосон байна.	1	14,289.8			1	14,289.8						
Тайлант онд 3 удаагийн сургалтын төлбөрийн нийт 1,500.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас зарцуулсан байна.	1	1,500.0					1	1,500.0				
Тайлант хугацаанд төсөвт тусгагдаагүй дараах ажлуудад	1	-					1	-				

санхүүжилт олгохоор тушаал гаргасан байна. Үүнд: гадаад албан томилолтын зардалд 3,443.5 мянган төгрөг, А/86 дугаар тушаалаар ахмадын санд цалингийн сангийн 1.0 хувиар санхүүжилт олгох, Б/62 тушаалаар 1 ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн төлбөрт 5,149.3 мянган төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн байна.												
Хувь хүний орлогын албан татвар төлөгчийн орлогод ногдуулах жилийн албан татварт албан татварын хөнгөлөлтийн хэмжээг эдлүүлэхдээ шаталбарыг буруу сонгож, 7 ажилтнаас 128.0 мянган төгрөгийг илүү суутгасан байна.	1	-					1	-				
Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл суутгаж тайлагнаагүй байна.	1	-					1	-				
Дүн	10	23,960.4	2	2,079.4	2	14,289.8	4	1,500.0	2	6,091.2		